

ЭРДЭНЭ РЕСУРС ХӨНДИЙ АЛТНЫ ТӨСЛИЙН ТАЛБАЙД ӨНДӨР АГУУЛГА БҮХИЙ ГУРВАН ШИНЭ БҮСИЙГ ТОДОРХОЙЛЛОО

2020 ОНЫ 3-Р УЛИРАЛД ДҮҮРГИЙН ХЭМЖЭЭНИЙ ӨРӨМДЛӨГИЙН ХӨТӨЛБӨРӨӨР ШИНЭ БҮСҮҮДИЙГ НАРИЙВЧЛАН СУДЛАХААР ТӨЛӨВЛӨВ

Онцлох тойм:

- 2020 оны 2-р улирлын хайгуулын хөтөлбөрөөр зүүн өмнөд Мидфийлд, баруун өмнөд Страйкер болон Хар Морь талбайнуудад газрын дөт гүнд, алтны өндөр агуулга бүхий дээжүүдийг илрүүлэв.
- Баруун өмнөд Страйкер бүсэд газрын гүнээс 25 метрт 100м*50м талбайд 11 цооног өрөмдөн, аномаль алт огтолсон.
 - ВКD-292 цооног 0.9 метрийн гүнээс эхлэн 353 г/т алтны агуулга бүхий 1 метр интервал багтаасан 29 г/т алтны агуулга бүхий 15 метрийн интервал огтолсон.
- Өнгөрсөн долоо хоногт танилцуулсан зүүн өмнөд Мидфийлд бүсийн өрөмдлөгийн үр дүнг бататгаж, Баян Хөндийн ил уурхайн нөөцөд бага агуулга бүхий материал хэмээн ангилагдсан талбайд алтны эрдэсжилтийг тэллээ.
- Баян Хөндий ордын нээлтээс хойш тусгай зөвшөөрлийн талбайд хийгдсэн шинэ нээлт болох Хар Морь талбайд суваг малталтаар өндөр агуулга бүхий бүсүүдийг тогтоов.
- 2020 оны 3-р улирлын өрөмдлөгийн хөтөлбөрөөр дээрх гурван хэтийн төлөв бүхий бүсийг өрөмдөхөөр төлөвлөв.

Хэвлэлийн мэдээ

Халифакс хот, Нова Скошиа муж
2020.07.15

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (TSX:ERD | MSE:ERDN) (“Эрдэнэ Ресурс” эсвэл “Компани”) нь өөрийн эзэмшлийн Баян Хөндий Алтны Төслийн (“Төсөл”) баруун өмнөд Страйкер бүсийн өрөмдлөг болон Баян Хөндий алтны ордоос хойд зүгт 3.5 км-т орших шинэ Хар Морь талбайн хайгуулын үр дүнгийн тухай мэдээлэл хүргэж байна.

Эрдэнэ Ресурсийн ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал Петер Акерли: “2-р улирлын хайгуулын хөтөлбөрөөр шалгасан талбайд гайхалтай үр дүнгүүд гарч, газрын дөт гүнд, өндөр агуулга бүхий огтлолуудыг тодорхойллоо. Өнөөдрийн үр дүн болон бидний саяхан танилцуулсан зүүн өмнөд Мидфийлд бүсийн үр дүнгүүдэд тулгуурлан энэ оны 3-р улиралд Баян Хөндий алтны дүүрэгт нэмэлт өрөмдлөг хийх өндөр агуулга бүхий гурван бүсийг тодорхойлсон.

Баруун өмнөд Страйкер бүсэд 353 г/т алтны агуулга бүхий 1 метр агуулсан 29 г/т алтны агуулга бүхий 15 метрийн интервал огтолсон нь одоогийн Баян Хөндий нөөцөд бага агуулга бүхий материал хэмээн тодорхойлогдсон бүсэд оршиж байгаагаараа онцлог юм. Өнгөрсөн долоо хоногт танилцуулсан зүүн

өмнөд Мидфийлд бүсийн 585 г/т алтны агуулга бүхий 1 метрийг багтаасан 126 г/т алтны дундаж агуулга бүхий 5.5 метрийн интервал зэрэг үр дүнгээр Баян Хөндийн бага агуулгатай материалын ангилалд багтсан бүсийн эрдэсжилтийг тэлсэн билээ. Эдгээр өрөмдлөгийн үр дүнгүүд ба 3-р улирлын өрөмдлөгийн үр дүнгээр Баян Хөндийн нөөцийг шинэчлэх боломжтой.”

“Хар Морь талбайн өндөр агуулга бүхий бүсэд хийсэн суваг малталтын үр дүнгээр энэхүү талбай нь Баян Хөндийн нээлтээс хойш тусгай зөвшөөрлийн талбайд хийсэн томоохон нээлт гэдгийг баталлаа. Бид 3-р улирлын өрөмдлөгийн хөтөлбөрөөрөө энэхүү сонирхолтой шинэ талбайд нарийвчилсан судалгаа хийхээр төлөвлөж байна” хэмээн танилцууллаа.

Хайгуулын үр дүнгийн онцлох тойм:

- Баруун өмнөд Страйкер өрөмдлөгийн үр дүн:
 - Газрын гадаргаас 25 метр гүнд 100м*50м талбайд өрөмдсөн 11 цооногт бүгдэд нь аномаль алт огтолсон (0.2 г/т алтны агуулгаас дээш).
 - ВКD-290 цооногийн амсраас 8 метрээс эхлэн 91.2 г/т алтны агуулга бүхий 1 метр интервал багтаасан 5.9 г/т алтны агуулга бүхий 20 метрийн интервал огтолсон.
 - ВКD-292 цооногийн амсраас 0.9 метрт 353 г/т алтны агуулга бүхий 1 метр интервал багтаасан 29 г/т алтны агуулга бүхий 15 метрийн интервал огтолсон.
 - ВКD-297 цооногт газрын гадаргаас эхлэн 4 г/т алтны агуулга бүхий 21 метрийн интервал огтолсон бөгөөд үүнд: 38.8 г/т болон 22.3 г/т алтны агуулгууд бүхий 1 метрийн интервалууд агуулсан.
 - Баян Хөндийн ашиглалтын эхний жилд олборлохоор төлөвлөсөн захын агуулгаас бага агуулга бүхий ангилалд багтсан бүсэд маш өндөр агуулга бүхий бүс үргэлжилж байгааг тодорхойллоо.
- Хар Морь талбайн хайгуулын үр дүн:
 - Хар Морь талбайн гол структурт КМТ-01 суваг малталтаар 50.8 г/т алтны агуулга бүхий 1 метр агуулсан 8.8 г/т алтны агуулга бүхий 6 метрийн интервал илрүүлсэн.
 - КМТ-01 сувгаас зүүн өмнө зүгт 850 метрт структурын огтлолд КМТ-03 суваг малталтаар 45.3 г/т алтны агуулга бүхий 1 метрийн интервал агуулсан 14 г/т алтны агуулга бүхий 4 метрийг огтоллоо.

Хүснэгт 1. Баруун өмнөд Страйкер өрөмдлөгийн үр дүнгүүд

Цооног	Хэдээс (м)	Хүртэл (м)	Интервал (м) ⁽¹⁾	г/т Алт ⁽²⁾
ВКD-290	8	28	20	5.91
Түүнд	12	28	16	7.35
Түүнд	14	15	1	91.18
ВКD-291	8	16	8	2.34
Түүнд	8	9	1	16.53
ВКD-292	0.9	23	22.1	20.0
Түүнд	0.9	16	15.1	29.1
Түүнд	3	4	1	11.94
Түүнд	5	6	1	353.00
Түүнд	6	7	1	23.83

BKD-293	17	21	4	0.16
BKD-294	0	17	17	1.06
Түүнд	4	11	7	2.05
BKD-295	3.7	8	4.3	0.65
BKD-296	14	19	5	1.75
BKD-297	0	21	21	4.02
Түүнд	4	5	1	38.78
Түүнд	5	6	1	22.31
Түүнд	18	19	1	16.55
BKD-298	12	15	3	1.19
BKD-299	7.3	11	3.7	0.25
BKD-200	16	17	1	1.76

- (1) Тайлагнасан интервал нь цооногийн огтлолын зузаан болно. Өрөмдлөгийн цооногууд нь баруун урд унал, баруун хойд баруун алтны судлыг огтлохоор чиглэсэн байсан тул мэдээлсэн зузаан нь бодит зузаантай маш ойрхон байна.
- (2) 5 г/т алтны агуулгаас дээш агуулга илэрсэн дээжүүдэд алтны шигшүүрийн шинжилгээ (screenmetallic gold analysis) хийсэн ба үр дүнг танилцуулсан

Хүснэгт 2. Хар Морь суваг малталтын үр дүн

Суваг	Хэдээс (м)	Хүртэл (м)	Интервал (м) ⁽³⁾	г/т алт ⁽²⁾
КМТ-01	9	15	6	8.82
Түүнд	12	13	1	50.84
Ба	53	60	7	0.23
КМТ-03	31	35	4	14.01
Түүнд	33	34	1	45.27
түүнд	34	35	1	10.54

- (3) Тайлагнасан интервалууд нь сувгийн доторх гадаргууны өргөн юм. Эдгээр сувгуудийн эрдэсжсэн судлуудын чиглэл нь одоогоор нарийн тодорхойлогдоогүй боловч эгц босоо байх боломжтой гэж үзэж байна. Энэхүү эрдэсжилтийн жинхэнэ зузааныг тодорхойлохын тулд нэмэлт хайгуул, өрөмдлөг хийх шаардлагатай.

Өрөмдлөгийн хөтөлбөрийн хураангуй – Баян Хөндий Страйкер бүсийн өрөмдлөг (Хавсралт зурагтай танилцана уу)

Нийт 280 тууш метрийн 11 цооногт өрөмдлөг хийсэн ба энэ нь төв Страйкер бүсийн хүдрийн биетээс баруун урд зүгт нийт 100м x 50м талбайг хамран дунджаар 21 метрийн босоо гүнд өрөмдөгдсөн. 2020 оны 2-р улирлын өрөмдлөгийн хөтөлбөрийн зорилго нь баруун өмнөд Страйкер бүсийн зүүн хэсэгт хийсэн өрөмдлөг, суваг малталтаар газрын дөт гүнд өндөр агуулга огтолсон бүсүүдийг баруун зүгт тэлэх байв. Хөтөлбөрөөр зорилтот талбайн баруун талд маш өндөр агуулга бүхий бүсийг тодорхойлж, 353 г/т алтны агуулга бүхий 1 метр агуулсан 10 г/т-оос дээш агуулга бүхий хэд хэдэн интервалыг огтолсон (Хавсралт зураг болон дээрх хүснэгтээс танилцана уу). 2020 оны 2-р улирлын хөтөлбөрөөр илрүүлсэн өндөр агуулга бүхий огтлолууд нь ордын одоогийн блок загварт бага агуулга бүхий эсвэл хаягдал материал хэмээн тодорхойлогдсон бүсүүд бөгөөд эдгээр шинэ үр дүн нь ордын энэ хэсгийн нөөцийн зэрэглэлд эергээр нөлөөлөх боломжтой. Өндөр агуулга бүхий алтны эрдэсжилт нь Баян Хөндийн туффыг хувиргасан цахиуржилт, цагаан гялтгануур, гематитийн хүчтэй хувирсан аномаль

алтаар хүрээлэгдсэн өмнө-баруун өмнө зүгт сунасан бүлэг кварц адууларын судлуудад оршиж байна. Баруун өмнөд Страйкер бүсийг уурхай ашиглалтын эхний жилд олборлохоор төлөвлөсөн.

Хар Морь талбайн суваг малталтын хөтөлбөр

Баян Хөндий алтны ордоос хойш 3.5 км зайд орших Хар Морь талбайд 2020 оны 6-р сард нарийвчилсан зураглалын ажил, тодорхой нягтрал бүхий торлолоор хөрс, чулуулгийн дээжлэлт, түүнчлэн 180 метрийн гурван суваг малталтын хөтөлбөрийг гүйцэтгэлээ. Суваг малталтын хөтөлбөрийн үр дүнгээр өндөр агуулга илэрсэн нь Хар Морь талбайг хэтийн төлөв сайтай болохыг баталлаа. Хөрс болон чулуулгийн дээжлэлт, зураглал болон суваг малталтаар гол структураас гадна хэд хэдэн хэтийн төлөв бүхий бүсийг тодорхойлсон. Кварцын биетийн үлдэгдэл, эрчимтэй цахиуржилт болон цагаан гялтгануурын хувирал мөн түүнчлэн давхацсан соронзон нам байдлаар тодорхойлогддог гол структур болох 1.3 км урт хөрс чулуулгийн аномаль нь Баян Хөндий ордтой ижил шинж чанартай юм. Алтны эрдэжилт нь комб кварц штокверкийн судал, цагаан гялтгануур (серицит) хувирал болон судлуудын хүчтэй цахиуржилт агуулагч литологид агуулагдаж байна (Хавсралт зурагтай танилцана уу).

КМТ-01-ээс КМТ-03 гурван сувгийг дээрх алт агуулагч бүсүүдэд судлын чиглэлийг хэмжих, зураглал, дээжлэлт авах зорилгоор малталт хийсэн. КМТ-01-ээс КМТ-03 сувгуудад өндөр агуулга бүхий алтны эрдэжилт буюу тус бүр 51 г/т ба 45 г/т алтны агуулга бүхий 1 метрийн интервал (нүдэнд үзэгдэх алт) илэрсэн нь комб-кварц штокверкийн бүсүүдтэй холбоотой ба хойд-баруун, хойд зүгт ерөнхий эгц уналтаар (330-340), түүнчлэн дэд комб кварц штокверк тренд нь урд-хойд зүгт чиглэж байна. КМТ-02 сувагт комб-кварц штокверкийн бүсүүд ажиглагдсан боловч аномаль алтны утга илрээгүй.

Хар Морь талбайн одоогийн тайллаар зүүн хойд чиглэлийн хагарлуудын дагуу, баруун хойд чиглэлийн хагарлуудтай огтлолцох гол зүүн хойд структурын дагуу байрласан комб кварц штокверк нягтралуудаар хянагдсан алтны эрдэжилтийн цуврал багтсан хэмээн ойлгогдож байна. Энэхүү эсрэг структуруудын огтлол нь шингэн урсгал болон дараалсан алтны давхарга үүсгэхэд тааламжтай бүсийг бий болгох боломжтой.

Хар Морь талбайд хязгаарлагдмал судалгаа хийсэн бөгөөд судлын дагуу томоохон нээлт хийх боломжтой гэж үзэж байна. 1.3 км структурын дагуу зүүн хойд зүгт хөрсөнд харьцангуй хүчтэй, үргэлжилсэн алтны аномаль ажиглагдсан (КМТ-01-ээс баруун өмнөд зүгт). КМТ-03-тай төстэй зүүн хойд-баруун хойд структурын огтлолтой ойролцоо хөрсөнд хэд хэдэн тусгаарлагдсан боловч хүчтэй хувирсан алтны аномаль илэрсэн. Бид чулуулаг болон сувгийн дээжлэлтийн үр дүнгээр алтны өндөр агуулга илэрсэн өрөмдлөг хийх боломжтой хэд хэдэн талбайг тодорхойлоод байна.

Хөндий Алтны Төслийн тухай

Эрдэнэ Ресурсийн ордууд нь дэлхийн томоохон алт, алт-зэсийн ордуудыг агуулагч Төв Азийн Орогены бүсэд багтдаг Эдрэнгийн террейнд байрладаг. Эрдэнэ Ресурс нь Монгол Улсын баруун өмнөд хэсэгт 10 гаруй жил хайгуул судалгааг хийн, өдгөө Хөндий алтны дүүргийг нээн илрүүлээд байна. Хөндий алтны дүүрэг нь өндөр агуулга бүхий алт, полиметаллын хэд хэдэн хэтийн төлөвт талбайг хамардгаас хоорондоо 16 км зайд орших Баян Хөндий, Алтан Нар ордуудыг ашиглалтын шатанд хүртэл хөгжүүлэхээр зорьж байна. Эдгээр ордуудыг хамтад нь Хөндий Алтны Төсөл (“Төсөл”) хэмээн нэрлэдэг.

Баян Хөндийд 3.16 г/т дундаж алтны агуулга бүхий 521,000 унц баттай болон бодит геологийн нөөц¹ (“Measured and Indicated Resources”)², түүнд 3.7 г/т алтны агуулга бүхий 420,000 унц батлагдсан болон магадалсан үйлдвэрлэлийн нөөц (“Proven and Probable Reserve”) багтаж байна. Түүнээс гадна 3.68 г/т алтны агуулга бүхий 103,000 унц боломжит нөөц (хэвлэлийн мэдээтэй [ЭНД](#) дарж танилцана уу) тодорхойлогдсон. Эдгээр нь уурхайн тэлэлт болон гүний уурхайн олборлолтоор үлдсэн баттай ба бодит болон боломжтой нөөцийг олборлох боломжийг нэмэгдүүлж байна.

2019 оны 10 сард Эрдэнэ Ресурс нь Хөндий Алтны Төслийн техникийн тайланг (Хэвлэлийн мэдээтэй [ЭНДЭЭС](#) танилцана уу) танилцуулсан бөгөөд энэхүү техникийн тайланд Баян Хөндий ордын (“Bayan Khundii”) урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл (“урьдчилсан ТЭЗҮ”, “PFS”) болон Алтан Нар ордын (“Altan Nar”) шинэчилсэн анхан шатны эдийн засгийн тооцоолол (“АШЭЗТ”) орсон болно. Урьдчилсан ТЭЗҮ-д Баян Хөндий, Алтан Нар ордын татварын дараах өнөөгийн цэвэр үнэ цэн (5% хорогдуулалт бүхий) (“NPV5%”) (алтны үнийг \$1,300 ам.доллар/унц байхаар төсөөлөхөд) тус бүр \$97 сая ам.доллар, \$24 сая ам.доллараар тооцоологдсон. Баян Хөндий ба Алтан Нарын дотоод өгөөжийн түвшин (“IRR”) нь тус бүр 42%, 90% гэж тооцоолсон. Урьдчилсан ТЭЗҮ-д 0-7 жилд Баян Хөндий ордыг ашиглах ба 3.73 г/т дундаж агуулга бүхий хүдрийг боловсруулж, жилд дунджаар 61,000 унц алтыг илээр олборлох, 7-10 жилүүдэд Алтан Нар ордыг ашиглан, 3.46 г/т дундаж агуулга бүхий хүдрийг боловсруулж, жилд дунджаар 48,000 унц алтыг олборлохоор төлөвлөж байна. Баян Хөндий ордод уламжлалт нүүрсэнд уусгах технологийн боловсруулах үйлдвэрийг байгуулахаар төлөвлөсөн. 2019 оны 8-р сард Баян Хөндий ордын ашиглалтын тусгай зөвшөөрлийг авсан бөгөөд компани нь төслийг олборлолтын шат руу хурдацтай хөгжүүлж байна.

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Монгол Улсад суурь болон үнэт металлын хайгуул, төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг Канад Улсад бүртгэлтэй хайгуулын компани юм. Компани нь Монгол Улсын баруун урд бүсэд хайгуул хийх эрх бүхий 3 хайгуулын, 3 ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг бөгөөд эдгээр хайгуулын бүсэд хийсэн судалгааны үр дүнд Хөндий Алтны Дүүргийг нээн илрүүлсэн. Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Торонто болон Монголын хөрөнгийн биржүүд дээр бүртгэлтэй. Компанийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг Компанийн вебсайт www.erdene.com-оос авч танилцах боломжтой. Компанийн талаарх чухал мэдээллүүд нь зөвхөн Компанийн вебсайтаар дамжин хүрдэг тул хөрөнгө оруулагчид вебсайтаар дамжуулан бодит мэдээллийг авахыг зөвлөж байна.

Мэргэшсэн этгээд (геологич) ба дээжлэлтийн протокол

Петер Далтон (Peter Dalton) нь Компанийн ахлах геологич (P.Geol, Nova Scotia) бөгөөд NI 43-101-т заасан мэргэшсэн этгээд ба урьдчилсан ТЭЗҮ, АШЭЗТ-оос бусад техникийн мэдээлэл, Баян Хөндийн эрдсийн баялаг, нөөцөөс бусад мэдээ мэдээллийг Эрдэнэ Ресурсийн зүгээс хянан баталгаажуулсан болно. Бүх дээжийг Улаанбаатар хот дахь Эс Жи Эс (“SGS”) лабораторид шинжлүүлсэн. Эс Жи Эс лабораторийн дотоод хяналт шалгалтаас гадна Компани нь тусгай стандарт бэлдэц, хээрийн болон лабораторийн хуулбар, мөн хүдэржилтгүй бэлдцийг ашиглан дээжийн чанарын хяналт, баталгаажуулалт (“QA/QC”)-ын протоколыг гүйцэтгэсэн. Бүх дээжид алтны агуулгыг стандарт

¹ Хөндий алтны төслийн эрдсийн нөөцийн дэлгэрэнгүй мэдээлэлтэй 2019 оны 12 сарын 4-нд SEDAR-т байршуулсан Тетра Текийн боловсруулсан NI 43-101 техникийн тайлангаас танилцана уу.

² Баттай ба бодит геологийн нөөц: 3.77 г/т алтны агуулга бүхий 171,000 унц баттай нөөц, 2.93 г/т алтны агуулга бүхий 349,700 унц бодит нөөц

Хайлуулах аргаар (fire assay), бусад 33 химийн элементийг Индукцын хос плазмет спектрометрийн арга (Inductively Coupled Plasma Optical Emission Spectroscopy) ашиглан тогтоосон. 5 г/т алтны агуулгаас дээш агуулга илэрсэн дээжүүдэд алтны шигшүүрийн шинжилгээ (screenmetallic gold analysis) хийсэн ба энэ нь 500 г дээжний 75 микроноос бага байх 30 г бүхий 3 дээж болон 75 микроноос том байх хэсгүүдэд хийгдсэн алтны хайлуулах (fire assay) шинжилгээнүүдийн жигнэсэн дунджаар илэрхийлэгддэг.

Эрдэнийн дээжлэлтийн протокол нь (хүдэржилт болон чулуулгийн төрлөөс хамаарч) зарим нэг жижиг, хүдэржилтийн дараа үеийн чулуулаг болон хүдэржилтгүй боржинг алгассан, 1 эсвэл 2 метрийн интервалтайгаар, цооногийг бүтнээр нь хамарсан дээжлэлтээс бүрддэг. Дээжлэлтийн интервалыг чөмгөн дээжний гүний метр дээр үндэслэдэг ба геологийн хяналт эсвэл хүдэржилтээс хамаардаггүй болно. Бүх дээжийг чөмгөн дээжний гүний метр дээр үндэслэн алмазан хөрөөгөөр 2 тэнцүү хуваадаг. Хуваагдсан дээжийн талыг дээжний уутанд ялган авч дээжилдэг бөгөөд үлдсэн талыг нь дээжний хайрцагт үлдээн Компанийн Баян Хөндий дэх хээрийн ангид аюулгүй байдлыг ханган хадгалдаг. Бүх дээжийг нэг багцандаа 30 дээж байхаар хуваарилдаг ба багц болгонд стандарт бэлдэц, хүдэржилтгүй бэлдэц, лабораторийн хуулбар болон хээрийн хуулбар дээж буюу дээжийг 4 хуваан, 2-ыг нь 2 тусад нь дээжлэн хийж Улаанбаатар дахь Эс Жи Эс (“SGS”) лаборатори руу шууд тээвэрлэдэг. Тээвэрлэлтийг Эрдэнийн ложистикийн гэрээт компани Монруд ХХК гүйцэтгэдэг.

Урьдчилсан таамаглал

Зарим мэдээллүүд нь Үнэт цаасны хуулийн хүрээнд урьдчилсан таамаглалуудыг агуулсан болохыг үүгээр мэдэгдэж байна. Урьдчилсан таамаглал нь урьд болж байсан болон ирээдүйд болох бодит баримт биш ба зөвхөн ирээдүйн төлөвлөгөө, стратеги, төсөл, нөхцөл байдалд тулгуурласан үзэл баримтлал, магадлал болон таамаглал болно. Энэхүү таамаглалууд нь тодорхой үндэслэлд тулгуурласан боловч баталгаа биш юм. Компанийн үйл ажиллагаа нь олон хүчин зүйлээс шалтгаалах бөгөөд зарим хүчин зүйлс нь Компанийн хяналтаас давсан байх магадлалтай ирээдүйд учирч болох хүчин зүйлс юм. Материаллаг өөрчлөлт үзүүлэх боломжтой хүчин зүйлсэд COVID-19 вирусийн тархалтаас үүсэх компанийн үйл ажиллагаанд нөлөөлж болох нөлөөлөл, гуравдагч талын зөвшөөрлийг авах, эрдсийн зах зээлийн үнэ, хайгуулын үр дүнгүүд, бизнесийн болон зах зээлийн орчин, эдийн засгийн байдал болон санхүүжилт, хөрөнгө босголт зэрэг орно. Дээр дурдсан мэдээллүүд нь ирээдүйд өөрчлөгдөн хувирах магадлалтай. Компани нь Үнэт цаасны хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд Урьдчилсан таамаглалыг өөрчлөн, шинэчлэх үүрэг хүлээхгүй.

ЭНЭХҮҮ МЭДЭЭЛЛИЙГ ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАХАД ЯМАРВАА НЭГЭН ЗАСАГ ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА ЗӨВШӨӨРСӨН, ҮЛ ЗӨВШӨӨРСӨН МЭДЭГДЭЛ ХИЙГЭЭГҮЙ.

Холбоо барих:

Петер К. Акерли, Ерөнхийлөгч болон Гүйцэтгэх захирал

Роберт Женкинс, Санхүү хариуцсан захирал

Утас: (902) 423-6419

Twitter: <https://twitter.com/ErdeneRes>

Facebook: <https://www.facebook.com/ErdeneResource>

LinkedIn: <https://www.linkedin.com/company/erdene-resource-development-corp/>

YouTube: <https://www.youtube.com/channel/UCILs5s9j3SLmya9vo2-KXoA>

BAYAN KHUNDII

New Khundii District Gold Targets – Q2 Exploration Results





**DARK HORSE (KHAR MORI)
GOLD PROSPECT**
Trenching and Chip Sampling
Results

BAYAN KHUNDII GOLD DEPOSIT:
Location of Q2 2020 Shallow Extensional
Drilling Program

Midfield SE Gold Zone



Striker SW Gold Zone



BAYAN KHUNDII

High Grade Gold Zones
Near Surface at Midfield SE and Striker SW

BAYAN KHUNDII
PROPOSED PIT
Plan View






-  High-Grade Gold Domain
-  Q2-2020 Drill Trace
-  Proposed Open Pit Boundary

300m

Striker SW Zone - Q2 2020 Drill Highlights


Plan View



DARK HORSE

Q2-2020 Exploration Highlights

Plan View



DARK HORSE (KHAR MORI)



GOLD PROSPECT

3D Magnetic Model and Structural Interpretation

High Priority Targets Along Strike and Depth

Oblique Section Looking NNE

Dark Horse Prospect



3D MAGNETIC SECTION WITH NORTHEAST STRUCTURES

